



**НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ**

2013 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 517

Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай

Монгол Улсын "Хөдөлмөрийн тухай" хуулийн 21, 23, 24 зүйл, 40 дүгээр зүйлийн 40.1.1 дэх заалт, Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 190 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2013 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/45 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Агаарын чанарын албаны бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан нэгдүгээр хавсралтад нэр заагдсан тус албаны дүүрэг хариуцсан гэрээт ажилтныг үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Батлагдсан бүтцийн дагуу хоёрдугаар хавсралтаар нэр заагдсан тус албаны дүүрэг хариуцсан гэрээт ажилтнуудыг албан тушаалд нь 2013 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

3. Дээрхи ажилтан, албан хаагчдад цалин болон холбогдох журмын дагуу унаа, хоолны хөнгөлөлт олгохыг нягтлан бодогч /П.Ариунаа/ -д зөвшөөрсүгэй.


4. Шинээр томилогдсон ажилтан, албан хаагчдын ажил үүргийг 2013 оны 03 дугаар сарын 05-ны дотор хүлээлцүүлж, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан, мөрдүүлж ажиллахыг дэд дарга /Х.Галымбек/, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга /Ч.Цог/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.БАТСАЙХАН


Нийслэлийн Агаарын чанарын албаны
даргын 2013 оны 02 дугаар сарын 26 ны
өдрийн 51А тушаалын нэгдүгээр
хавсралт



АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫГ АЖЛААС ЧӨЛӨӨЛСӨН ЖАГСААЛТ

№	Эцэг/эх-ийн нэр	Нэр	Албан тушаал
1	Лхамсүрэн	Баярцэнгэл	Хан-Уул дүүрэг хариуцсан гэрээт
2	Сүхбат	Чулуундорж	Агуулах хариуцсан гэрээт

Нийслэлийн Агаарын чанарын албаны
даргын 2013 оны 02 дугаар сарын 26 ны
өдрийн 6/7 тушаалын хоёрдугаар хавсралт



АЖИЛД ТОМИЛСОН ГЭРЭЭТ АЖИЛЧДЫН НЭРС, ЦАЛИНГИЙН ХҮСНЭГТ /сараар/

№	Эцэг/эх-ийн нэр	Нэр	Албан тушаал	Ангилал	Үндсэн цалин
1	Лхамсүрэн	Баярцэнгэл	Баянзүрх дүүрэг хариуцсан	ТҮ 3-4	374,948